



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 481

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 4.5 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Ойн судалгаа хөгжлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 80,541,021.00 (наян сая таван зуун дөчин нэгэн мянга хорин нэгэн) төгрөгийн балансын үнэ, бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Ойн судалгаа хөгжлийн төвийн захирал Д.Мөнхбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу тухайн улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны дүгээр сарын 28-ны өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт

**ОЙ СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
 БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

| Д/д | Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл | Сэргээн босголтын зардал /төгрөг/ | | Худалдах доод үнийн санал |
|-----------------|--|------------------------------------|-----------------|---|-----------------------------------|---|---------------------------|
| | | | | | | | |
| 1 | Ланд круйзер-105, арал 4Т1ве30к43Uo 73-12 УБН | 2003/2004 | 304,482.00 | 60,541,028.00 | - | - | 6,000,000.00 |
| 2 | Тоёота Камри, арал 4Т1ВЕ30К43U058065, 09-07 УНУ | 2007/2008 | 145,995.00 | 20,000,000.00 | - | - | 3,000,000.00 |
| Нийт дүн | | | | 80,541,028.00 | - | - | 9,000,000.00 |
| | | | | (наян сая таван зуун дөчин нэгэн мянга хорин нэг) | | | |
| | | | | (есөн сая) | | | |